



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН
ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ХЭА-2021/1/СТА-ТЕЗ

ХЭНТИЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН
НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чингис хот 2021 он
Цахим хуудас: www.audit.mn

Тэргүүлэх аудитор:	Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112	
Аудитын менежер:	Д.Оюунтуяа
Утас: 99775390	
Ахлах аудитор:	Н.Туяа
Утас: 99799709	
Аудитор:	Ц.Нарангэрэл
Утас: 99028942	
Аудитор:	Х.Еркегүл
Утас: 99040705	

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг

khentii@audit.gov.mn хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ.....	3
2. Аудитын тайлан	5
2.1. Оршил.....	5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	5
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	8
2.8.2 Авлага.....	10
2.8.3 Урьдчилгаа.....	12
2.8.4 Урт хугацаат хөрөнгө оруулалт.....	13
2.8.5 Бараа материал	14
2.8.6 Нөөцийн бараа	16
2.8.7 Үндсэн хөрөнгө	16
2.8.9 Өр төлбөр.....	18
2.8.10 Засгийн газрын хувь оролцоо	19
2.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	20
2.10. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	23
2.11. Шилэн дансны мэдээлэл	24
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	24
2.13. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	25
2.14. Аудитын зөвлөмж	26
3. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	27
3.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	27
3.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан.....	28
3.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан	29
3.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	31
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	32
3.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	34
4.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	
5. Албан шаардлага 1, 2	

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
СТОУС	Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНӨААН	Орон нутгийн өмчит аж ахуй нэгж
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ЖДБДС	Жижиг дунд бизнесийг дэмжих сан
БСШУЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
БХБЯ	Барилга хот байгуулалтын яам
ХНХЯ	Хөдөлмөр нийгэм хамгааллын яам
УТХО	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ЗАА	Захирагчийн ажлын алба

1. Аудитын гэрчилгээ



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2021.04.25 № 460
танай _____ -ны № _____ -г

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Ц.ИДЭРБАТ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Хэнтий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Бусад мэдээлэл нь (Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл) санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

0 3030597

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Хэнтий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг аймгийн Засаг дарга Ц.Идэрбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Хэнтий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэнтий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн ерөнхийлөн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, НББОУС, СТОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2021 оны 04 дүгээр сарын 12-оос 2021 оны 04 дүгээр сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Н.Туяа, аудитор Ц.Нарангэрэл, Х.Еркегүл нар хариуцаж гүйцэтгэв.

Хэнтий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 3/649 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэн, шат шатны чанарын хяналт хийж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитыг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болгож, батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хэрэгжүүлэв.

2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Хэнтий аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгасан “Ард иргэдийнхээ эрх ашгийг дээдэлж, тэдний санал, санаачилгад тулгуурлан хувь хүн, өрх гэрийн хөгжлийг эрхэмлэж, баялгийг бүтээгч иргэд бүхий, байгаль орчинд ээлтэй, аж үйлдвэр, хөдөө аж ахуй, аялал жуулчлалын шинэ хөгжилд хүрэх хүний амьдрах, ажиллах, хөгжих таатай орчныг бүрдүүлсэн **“Иргэндээ ээлтэй”** аймаг болох гэж зорилгоо тодорхойлон ажилласан байна.

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан аймгийн Засаг даргын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- ✓ Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн Хуралд оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- ✓ Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, Хурлын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах;
- ✓ Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, тухайн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;
- ✓ Төрийн бодлого, хууль тогтоомж, Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх;
- ✓ Нутаг дэвсгэрийнхээ газрыг зүй зохистой ашиглах, газар тариалангийн үйлдвэрлэлийг дэмжих, үржил шимийг нь дээшлүүлэх, байгаль орчныг хамгаалах бусад арга хэмжээний цогцолбор хөтөлбөрийг боловсруулж Хуралд өргөн мэдүүлэх, батлагдсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
- ✓ Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах;
- ✓ Нутаг дэвсгэртээ боловсрол, соёл, эрүүл мэнд, биеийн тамир, спортын талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, тухайн Хурлын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;
- ✓ Хууль тогтоомж, Засгийн газар, Хурал, Засаг даргын шийдвэрийг сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах;
- ✓ Хууль тогтоомжид заасан бусад.

Тайлант хугацаанд аймгийн ТЕЗ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ✓ 2020 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;
- ✓ Нийгмийн даатгалын тухай хуулиар нийгмийн даатгалын хувь хэмжээ өөрчлөгдсөнтэй холбоотой;
- ✓ МУ-ын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдад олгох төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадвар, илүү цаг, мэргэшлийн зэрэг, орон нутагт ажилласны, ЭМ-ийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчид хөдөлмөрийн нөхцөлийн нэмэгдэл олгохтой холбоотой;
- ✓ МУ-ын Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор төрийн албан хаагчид шагнал, мөнгөн урамшуулал олгохтой холбоотой;
- ✓ МУ-ын Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдад нөхөх төлбөр олгохтой холбоотой;

- ✓ МУ-ын Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээний шинэчлэлттэй холбоотой;
- ✓ Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалттай холбоотой журам;
- ✓ Сангийн сайдын 2018 оны 301 дүгээр тушаалаар “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” /ТАХ-ийн албан томилолтын зам хоног, зардлыг шинэчлэх/;
- ✓ Хэнтий аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 12 дугаар хуралдааны 08 дугаар тогтоолоор “Аймгийн 2019 оны төсөв батлах тухай” тогтоол;
- ✓ Хэнтий аймгийн ИТХ-ын 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 15 дугаар хуралдааны 01 дүгээр тогтоолоор “Аймгийн 2020 оны төсвийн тодотгол батлах тухай” тогтоолоор өөрчлөлтүүд орсон байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас урьдчилан сэргийлэх, үр нөлөөтэй ажиллаж гол хяналтуудыг тодруулах, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг бууруулах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах зорилготой юм.

Өмнөх аудитаар Хэнтий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн шууд захирагч 58 байгууллага санхүүгийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж мөрдөөгүй, 8 байгууллага бодлогын баримт бичиг боловсруулсан боловч холбогдох стандарт, заавар журмын дагуу шинэчлээгүй зөрчилд зөвлөмж өгснийг 57 байгууллага хэрэгжүүлж, Хэрлэн сумын Соёлын төв хэрэгжүүлээгүй байна.

Хэнтий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

Хэнтий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн Төсвийн тухай хуулийн 69.1-д “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна” гэсэн заалтын дагуу Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх аймгийн Санхүүгийн хяналт, аудитын алба нь дотоод хяналтыг хэрэгжүүлж байна.

Тус байгууллага нь эрсдэлийн ангилалд үндэслэн 2020 онд төлөвлөгөөт хяналт шалгалтыг 53 газарт, дотоод аудитыг 14 газарт, харьяа дээд байгууллага болон иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын мөрөөр буюу төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 10 газарт, нийт 77 объектод санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг хийжээ.

Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар 63 танилцуулга, 14 дүгнэлт, 36 зөвлөмж, зөрчил арилгуулах 26 албан шаардлагыг тус тус гаргаж хүргүүлсэн байна.

Албан шаардлагын биелэлт 100 хувь, өмнөх оны актын үлдэгдэл 15,828.0 мянган төгрөгөөс 3,871.7 мянган төгрөгийг барагдуулж 11,956.3 мянган төгрөгийн актыг шүүхэд шилжүүлсэн гэж тайлагнажээ.

Аудитын явцад Засгийн газрын 2011 оны 311-р тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 4.1 "Дотоод хяналт шалгалтыг дараах чиглэлээр зохион байгуулна." 4.1.5. "Өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд тавих хяналт шалгалт" гэсэн заалтын дагуу байгууллагын дотоод хяналтын нэгж санхүүгийн үйл ажиллагаанд хяналтыг хэрэгжүүлсэн эсэхийг шалгахад 38 байгууллага хэрэгжүүлээгүй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Хэнтий аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 8 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшнийг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2019 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 82,825.2 сая төгрөгийн 1 хувь буюу 828.3 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг тайлант оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар буюу 1,098.9 сая төгрөгөөр тогтоосон нь эрсдэлийн түвшнийг дунд гэж үнэлсэнтэй холбоотой болно.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшин 270.6 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд цалин хөлсний зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

2.8 Аудит хийгдсэн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, аудитын дүн

2.8.1 Мөнгөн хөрөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 6,935.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 12,257.7 сая төгрөг болж 5,321.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	4.4	5.8	1.4
Төгрөг	4.4	5.8	1.4
Нэмэлт санхүүжилт	-	-	-
Банканд байгаа бэлэн мөнгө	6,899.1	12,209.6	5,310.5
Замд яваа мөнгөн хөрөнгө	32.4	42.3	9.9
Хадгаламж			-
Дүн	6,935.9	12,257.7	5,321.8
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>			
Төсөвт байгууллага	2007.8	2637.1	629.3
Төсөл/ сан		245.8	245.8
Төрийн сан	4783.6	9315.5	4531.9
ТӨҮГ болон ОНӨҮГ	144.5	59.3	-85.2
Дүн	6935.9	12257.7	5321.8

Эх сурвалж: Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Касст байгаа бэлэн мөнгөний үлдэгдэл 5.8 сая төгрөгөөс 72.4 хувь буюу 4.2 сая төгрөг нь Хэнтий-Ус ХХК-ний үлдэгдэл байна.

Банканд байгаа бэлэн мөнгөний 12,209.6 сая төгрөгийн үлдэгдлээс 12,155.9 сая төгрөг төрийн сангийн харилцах дансанд, 53.7 сая төгрөг арилжааны банканд байршиж байна.

Замд яваа мөнгөн хөрөнгийн 42.3 сая төгрөгийн үлдэгдлээс 16.2 сая төгрөг аймгийн татварын орлого, 26.1 сая төгрөг нь сумдын татварын орлого байна.

Төрийн сангийн мөнгөн хөрөнгө

Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 4,783.6 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 9,315.5 сая төгрөг болж, 4,531.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №2 Төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа мөнгөн хөрөнгө	4,751.1	9,273.2	4,522.1
Төгрөг	4,751.1	9,273.2	4,522.1
Төрийн сан	4,751.1	9,273.2	4,522.1
Монгол банк			-
Арилжааны банк		-	-
Гадаад валют			-
Монгол банк			-
Замд яваа хөрөнгө	32.5	42.3	9.8
Нийт дүн	4,783.6	9,315.5	4,531.9

Эх сурвалж: Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд орон нутгийн төсвөөс 27,158.9 сая төгрөг, ОНХС-аас 7,240.5 сая төгрөг, БСШУЯ-аас тусгай зориулалтын шилжүүлэг 33,093.4 сая төгрөг, ЭМЯ-аас тусгай зориулалтын шилжүүлэг 6,309.8 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын санхүүжилт 356.3 сая төгрөг, БХБЯ-аас тусгай зориулалтын шилжүүлэг 562.0 сая төгрөг, ХНХЯ-аас тусгай зориулалтын шилжүүлэг 298.7 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 1,023.7 сая төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 247.9 сая төгрөг төвлөрүүлж, нийт 76,291.2 сая төгрөгийн санхүүжилт, орлогын эх үүсвэртэй ажилласан байна.

Үүнээс 68,903.4 сая төгрөгийг харьяа байгууллагуудын урсгал санхүүжилтэд, 7,363.9 сая төгрөгийг хөрөнгө оруулалтын санхүүжилтэд, 914.3 сая төгрөгийг сангийн эргэж төлөгдөх зээлд, нийт 77,181.6 сая төгрөг зарцуулжээ.

Аудитын илрүүлэлт:

Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой дансны бичилт буруу хийсэн, төсвийг үр ашиггүй зориулалт бус зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэл дутуу, холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн зэрэг нийт 441.9 сая төгрөгийн алдаа, зөрчлүүд илэрсэн. Үүнээс 33.7 сая төгрөгийн алдаа, зөрчлийг санхүүгийн тайланд залруулсан байна.

Залруулаагүй алдаа, зөрчлийг зөрчлийн утга, сум, байгууллагаар нь дурдвал:

Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу, хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн 79.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Аймгийн Засаг даргын нөөц сан- 11.7 сая төгрөг
- Ангилагдаагүй зардал – 12.0 сая төгрөг
- Биеийн тамир спортын газар -3.4 сая төгрөг
- Норовлин сумын ЗДТГ – 21.5 сая төгрөг
- Хэрлэн сумын ИТХ- 1.8 сая төгрөг
- Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар – 27.8 сая төгрөг
- Биндэр сумын ЕБС – 1.1 сая төгрөг

Төсвийг үр ашиггүй, зориулалт бус зарцуулсан 159.4 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Аймгийн Засаг даргын нөөц сан- 18.6 сая төгрөг
- Хэрлэн сумын 1-р сургууль – 12.5 сая төгрөг
- Аймгийн ЗДТГ -0.7 сая төгрөг
- Биеийн тамир спортын газар -9.4 сая төгрөг
- Биндэр сумын ЕБС -8.8 сая төгрөг

- Дархан сумын ЕБС -3.4 сая төгрөг
- Бор-Өндөр сумын 3-р Цэцэрлэг -2.4 сая төгрөг
- Батширээт ЭМТ -3.1 сая төгрөг
- Өлзийт тосгоны ЕБС -3.2 сая төгрөг
- Баян-Адарга сумын ЕБС-3.7 сая төгрөг
- Хэрлэн сумын Засаг даргын нөөц сан – 1.6 сая төгрөг
- Норовлин сумын ЕБС – 3.8 сая төгрөг
- Дадал сумын Цэцэрлэг – 0.9 сая төгрөг
- Биндэр сумын ЕБС -2.1 сая төгрөг
- Норовлин сумын ЗДТГ – 4.3 сая төгрөг
- Гурванбаян сумын ЕБС – 4.1 сая төгрөг
- Хэрлэн сумын Ясли -0.6 сая төгрөг
- Баян-Овоо сумын Цэцэрлэг -23.7 сая төгрөг
- Мөрөн сумын сургууль - 2.5 сая төгрөг
- Баянхутаг сумын ЗДТГ -5.5 сая төгрөг
- Норовлин сумын Соёлын төв – 7.1 сая төгрөг
- Санхүүгийн хяналт аудитын алба – 2.3 сая төгрөг
- Бор-Өндөр сумын ИТХ -10.3 сая төгрөг
- Хэрлэн сумын 1-р цэцэрлэг -4.1 сая төгрөг
- Оюуны шим өрхийн эмнэлэг – 2.8 сая төгрөг

Төрийн албаны тухай хуулийн 46.2.2 дах заалтаар тэтгэвэрт гарсан иргэдийг томилон ажиллуулж, мөн гэрээт ажилтанд ТА-ын тухай хуулийн дагуу олгох цалингийн нэмэгдэл, урамшуулалд нийт 13.7 сая төгрөгийг олгосон байна. Үүнд:

- Бэрх тосгоны Цэцэрлэг – 3.7 сая төгрөг
- Бэрх тосгоны ЕБС -0.7 сая төгрөг
- Хан Хэнтий чуулга – 9.3 сая төгрөг

Түрээсийн орлогын 40 хувийг төсөвт бүрэн төвлөрүүлээгүй 9.1 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна. Үүнд:

- Хэнтий-Ус ХХК -3.8 сая төгрөг
- Хэрлэн сумын ЕБ-ын 1-р сургууль -1.5 сая төгрөг
- Өмнөдэлгэр сумын ЗДТГ- 1.2 сая төгрөг
- Хэрлэн сумын ЗДТГ- 0.8 сая төгрөг
- Бэрх тосгоны Соёлын төв -0.7 сая төгрөг
- Хэрлэн сумын Хан Хэнтий цогцолбор сургууль -0.4 сая төгрөг
- Өндөрхаан тохижилтын газар -0.3 сая төгрөг
- Мөрөн сумын ЭМТ -0.2 сая төгрөг

Дотоод хяналт болон хариуцлагатай холбоотой 20.2 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Биеийн тамир спортын газар -7.4 сая төгрөг
- Хэнтий -Ус ХХК -4.2 сая төгрөг
- Өндөрхаан хот тохижилт -7.2 сая төгрөг
- Хэрлэн сумын ЗДТГ-0.9 сая төгрөг

Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 126.0 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Норовлин сумын ЭМТ -22.8 сая төгрөг
- Мөрөн сумын ЭМТ – 31.4 сая төгрөг
- Дархан сумын ЭМТ -17.5 сая төгрөг
- Оюуны шим өрхийн эмнэлэг -47.5 сая төгрөг
- Хэнтий-Ус ХХК -3.8 сая төгрөг
- Норовлин сумын Соёлын төв -2.5 сая төгрөг

2.8.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 8,260.5 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 8,417.4 сая төгрөг болж, 156.9 сая төгрөгөөр өссөн төгрөгөөр байна.

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	20.2	15.3	(4.9)
Төлбөртэй үйлчилгээний авлага	-	0.1	0.1
Татаас, санхүүжилтийн авлага	26.3	1.6	(24.7)
Зээлийн хүүгийн авлага			
Дансны авлага /ТӨҮГ/	576.0	404.8	(171.2)
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	0.4	3.9	3.5
Бусад авлага	703.8	1,020.7	316.9
Зээлийн авлага	6,933.8	6,971.0	37.2
Дүн	8,260.5	8,417.4	156.9
Үүнээс, байгууллагын төрлөөр			-
Төсөвт байгууллага	7,252.9	7,503.4	250.5
Төсөл/ сан	275.1	275.1	-
Төрийн сан	30.0	53.9	23.9
ТӨҮГ болон ОНӨҮГ	702.5	585.0	(117.5)
Дүн	8,260.5	8,417.4	156.9

Эх сурвалж: Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт авлагын 89.1 хувийг төсөвт байгууллага, 3.3 хувийг төсөл сан, 0.6 хувийг Төрийн сан, 7 хувийг ОНӨҮГ-ын үлдэгдэл эзэлж байна.

Төсөвт байгууллагын авлагын үлдэгдэлд Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн 4,614.6 сая төгрөг, Жижиг дунд бизнесийг дэмжих сангаас олгосон 2,463.1 сая төгрөг, нийт 7,077.7 сая төгрөг авлагын 84 хувийг эзэлж байна. Үүнээс:

Сум хөгжүүлэх сан 1,530.7 сая төгрөгийн, ЖДБДС 1,755.6 сая төгрөгийн үлдэгдэл тус тус хугацаа хэтэрчээ.

Төсөл сангийн авлагад Орон сууцны сангаас олгосон 275.1 сая төгрөгийн үлдэгдэл нь өмнөх оноос өөрчлөлт ороогүй байна.

ОНӨААН-ийн авлагын үлдэгдэлд Хэнтий-Ус ХХК-ний иргэд, байгууллагаас авах цэвэр, бохир ус, дулаан, засвар үйлчилгээний 464.3 сая төгрөгийн, Бор-Өндөр Хот тохижилт ОНТҮГ-ын иргэд, байгууллагаас авах бохир ус, хог хаягдлын үйлчилгээний 107.6 сая төгрөгийн авлага ихэнх хувийг эзэлж байна.

Төрийн сангийн авлага ЗГ-ын байгууллага, бусад шатны төсөвт олгосон зээлийн авлагын 30.0 сая төгрөгийн үлдэгдэл хэвээр, тайлант онд 23.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь АЗДТГ-ын нэмэлт дансанд төвлөрүүлсэн дүйцүүлэх мөнгөн төлбөрийн орлогыг буцаан авахаар тооцож аудитаар залруулсан байна.

Аудитын илрүүлэлт:

Авлагын данстай холбоотой дансны бичилт буруу хийсэн, авлагыг бүртгэлд тусгаагүй, үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй, авлагыг хугацаанд нь барагдуулаагүй, бүртгэлийг аккруэл сууриар хөтлөөгүй, олон жилийн насжилттай авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй зэрэг нийт 3,596.1 сая төгрөгийн алдаа, зөрчлүүд илэрсэн. Үүнээс 137.9 сая төгрөгийн алдаа, зөрчлийг санхүүгийн тайланд залруулсан байна. Илэрсэн алдаа, зөрчлийг томоохон дүнтэй сум, байгууллагаар нь дурдвал:

Сумдын СХС, ЖДБДС -аас олгосон зээлийн хугацаа хэтэрсэн болон олон жилийн насжилттай дараах авлагуудыг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй 3,446.3 сая төгрөгийн зөрчилтэй байна. Үүнд:

- Хэрлэн сумын ЖДБДС-431.4 сая төгрөг
- Хэрлэн сумын СХС – 231.5 сая төгрөг

- Баян-Адарга сумын ЖДБДС -82.1 сая төгрөг
- Баян-Адарга сумын СХС – 38.9 сая төгрөг
- Баян-Овоо сумын ЖДБДС -62.1 сая төгрөг
- Баян-Овоо сумын СХС -77.1 сая төгрөг
- Бор-Өндөр сумын СХС, ЖДБДС – 682.7 сая төгрөг
- Норовлин сумын СХС -42.3 сая төгрөг
- Галшар сумын ЖДБДС -60.7 сая төгрөг
- Галшар сумын СХС -31.6 сая төгрөг
- Жаргалтхаан сумын ЖДБДС – 34.0 сая төгрөг
- Жаргалтхаан сумын СХС – 120.3 сая төгрөг
- Цэнхэрмандал сумын ЖДБДС -30.7 сая төгрөг
- Цэнхэрмандал сумын СХС -89.4 сая төгрөг
- Гурванбаян сумын СХС -36.3 сая төгрөг
- Дархан сумын ЖДБДС -11.0 сая төгрөг
- Дархан сумын СХС -22.1 сая төгрөг
- Баянмөнх сумын ЖДБДС -9.5 сая төгрөг
- Баянмөнх сумын СХС -12.1 сая төгрөг
- Өмнөдэлгэр сумын СХС-139.7 сая төгрөг
- Батширээт сумын СХС -30.7 сая төгрөг
- Биндэр сумын СХС -44.4 сая төгрөг
- Бэрх тосгоны ЖДБДС -111.0 сая төгрөг
- Баянхутаг сумын ЖДБДС -79.7 сая төгрөг
- Баянхутаг сумын СХС -123.7 сая төгрөг
- Дэлгэрхаан сумын ЖДБДС -58.7 сая төгрөг
- Дэлгэрхаан сумын СХС -62.3 сая төгрөг
- Дадал сумын ЖДБДС -22.5 сая төгрөг
- Батноров сумын СХС -19.0 сая төгрөг
- Мөрөн сумын ЖДБДС- 79.5 сая төгрөг
- Мөрөн сумын СХС -115.8 сая төгрөг
- Өлзийт тосгоны СХС -1.4 сая төгрөг
- Хэрлэнбаян-Улаан тосгоны СХС -1.0 сая төгрөг

Олон жилийн насжилттай 400.3 сая төгрөгийн дараах авлагуудыг барагдуулаагүй байна.

- Аймгийн Газар тариаланг дэмжих сан-4.9 сая төгрөг
- Аймгийн ЖДБДС-108.6 сая төгрөг
- Аймгийн Орон сууцны сан-275.1 сая төгрөг

Авлага барагдахгүй байгаа нь төсвийн хөрөнгө үрэгдэх, зээлийн эргэн төлөлт бүрэн хийгдээгүйгээс сангийн эх үүсвэр бүрдэхгүй, найдваргүй авлагад шилжих зэрэг эрсдэл үр дагаврыг бий болгож байна.

2.8.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 39.0 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 304.2 сая төгрөг болж 265.2 сая төгрөгөөр төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/ Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	25.0	240.1	215.1
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	0.1	4.1	4.0
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	8.5	53.9	45.4
Цалингийн урьдчилгаа	5.5	6.1	0.6
Томилолтын урьдчилгаа			-
Дүн	39.1	304.2	265.1
Үүнээс, байгууллагын төрлөөр			-
Төсөвт байгууллага	38.9	304.1	265.2
Төсөл/ сан			-
Төрийн сан			-

ТӨҮГ болон ОНӨҮГ	0.1	0.1	-
Дүн	39.0	304.2	265.2

Эх сурвалж: Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд Бор-Өндөр сумын ЗДТГ-ын өмнөх онд 8.5 сая төгрөгийн төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр худалдан авах ажиллагаанд оролцож, гэрээ байгуулан урьдчилгаа 50 хувь олгосон нь үлдэгдэлтэй хэвээр байна.

Бор-Өндөр сумын ЕБС 6.0 сая, Дархан сумын ЕБС 9.4 сая, Цэцэрлэг 0.1 сая, Цэнхэрмандал сумын ЗДТГ 29.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа, Дархан сумын Цэцэрлэг 4.0 сая төгрөгийн, Гурванбаян сумын ЗАА 0.1 сая төгрөгийн бараа материал бэлтгэх урьдчилгаа дансанд үлдэгдэлтэй байна.

Цалингийн урьдчилгаа дансанд 6.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас өмнөх онд үлдэгдэлтэй байсан Оюуны шим өрхийн эмнэлэг, Биндэр сумын Цэцэрлэг, Баянмөнх сумын Соёлын төв, Гурванбаян ЗАА, Мөрөн сумын ИТХ, Хэрлэн сумын ЗДТГ -ын нийт 3.0 сая төгрөгийн үлдэгдэл төлөгдөөгүй хэвээр байна.

Урьдчилж гарсан зардал дансны үлдэгдэл өссөн нь орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 98.3 сая төгрөгөөр санхүүжүүлээд бүрэн дуусаагүй төсөл арга хэмжээний зардлыг бүртгэсэн болон төсөвт байгууллагууд хөрөнгө бэлтгэх зардал гаргасантай холбоотой байна.

2.8.4 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалт эхний үлдэгдэлгүй, эцсийн үлдэгдэл 4,931.5 сая төгрөг болж байна.

Хүснэгт № 5 Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		4,931.5	4,931.5
Урт хугацаат хадгаламж			
Үнэт цаас			
Урт хугацаат зээл	-	4,931.5	4,931.5
Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	-	4,931.5	4,931.5
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөвт олгосон		4,931.5	4,931.5
Дүн		4,931.5	4,931.5
Үүнээс, байгууллагын төрлөөр			
Төсөвт байгууллага			
Төсөл/ сан			
Төрийн сан		4,931.5	4,931.5
ТӨҮГ болон ОНӨҮГ			
Дүн		4,931.5	4,931.5

Эх сурвалж: Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урт хугацаат хөрөнгө оруулалтын 4,931.5 сая төгрөгийн үлдэгдэл нь Сангийн яам аймгийн ЗДТГ -тай 2019 онд байгуулсан дамжуулан зээлдүүлэх гэрээний дагуу Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Зүүн өмнөд говийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилт” төслөөс цэвэрлэх байгууламж байгуулах зориулалтаар олгох 4,931.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг тусгасан байна.

Аудитын илрүүлэлт:

Урт хугацаат хөрөнгө оруулалтын 4,931.5 сая төгрөгийн үлдэгдлийг аймгийн төрийн сангийн орон нутгийн ерөнхий орлогын дансанд тусгасан нь хариуцах байгууллага тодорхой биш, хяналтыг сулруулах нөхцөл үүссэн байна.

2.8.5 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 11,059.8 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 20,981.9 сая төгрөг болж 9,922.1 сая төгрөгөөр байна.

Хүснэгт №6 Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бараа материал			
Тусгай зориулалтын материал	602.9	835.4	232.5
Эм боох материал	409.7	482.9	73.2
Дуусаагүй үйлдвэрлэл	123.7	10.0	(113.7)
Бэлэн бүтээгдэхүүн	18.5	24.3	5.8
Бичиг хэргийн материал	219.0	307.5	88.5
Аж ахуйн материал	2,961.2	3,873.4	912.2
Сэлбэг хэрэгсэл	92.0	151.4	59.4
Түлш, шатах тослох материал	172.9	180.4	7.5
Барилгын засварын материал	150.7	152.3	1.6
Хүнсний материал	255.7	129.6	(126.1)
Бусад хангамжийн материал	10,056.4	14,123.0	4,066.6
Мал амьтад	768.2	711.7	(56.5)
Дүн	11,059.8	20,981.9	9,922.1
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>	-	-	
Төсөвт байгууллага	10,292.4	20,214.3	9,921.9
Төсөл/ сан	-		-
Төрийн сан	-		-
ТӨҮГ болон ОНӨҮГ	767.4	767.6	0.2
Дүн	11,059.8	20,981.9	9,922.1

Эх сурвалж: Хэнтий аймгийн ТЕЗ-ийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын үлдэгдэл 9,922.1 сая төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 5,558.6 сая төгрөг, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 17.6 сая төгрөг, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 1,691.6 сая төгрөгөөр тус тус хийгдсэн ажлууд нь он дамжин хийгдэж, улсын комиссоор хүлээн аваагүй тул бусад хангамжийн материал дансанд үлдэгдлээр бүртгэсэн нь нөлөөлсөн байна. Үүнд:

Аймгийн ОНХС-ийн сангийн хөрөнгө оруулалт:

- Хэрлэн сумын 1-р багт аялал жуулчлалын гудамж байгуулах /Монголын эзэнт гүрний Мини парк/- 539.0 сая төгрөг,
- "Сумын шинэ төв" дэд хөтөлбөр-Баян-Овоо сумын инженерийн шугам сүлжээ /үргэлжлэл/ -150.0 сая төгрөг,
- Хэрлэн сумын багуудын гэр хороололд жишиг гудамж бий болгох 300.0 сая төгрөг,
- Халуун усны барилга Норовлин сум 70.0 сая төгрөг,
- Халуун усны барилга Хэрлэн сум 70.0 сая төгрөг,
- Хэрлэн сумын 1-р багийн халаалтын зуухны дуусгал 257.1 сая төгрөг,
- Ахуйн үйлчилгээний төв байгуулах /Мөрөн сум/ 57,6 сая төгрөг,
- Хуучин сургуулийн барилгыг засварлаж хүүхэд хөгжлийн төв, ахуйн үйлчилгээний төв байгуулах /Цэнхэрмандал/ 60.0 сая төгрөг,
- Хуучин соёлын төвийг засварлаж ахуйн үйлчилгээний төв болгох /Баянмөнх сум/ 80.0 сая төгрөг,
- Чингис хотын бохир усны төв коллекторын шугамын шинэчлэлийн ажлын зураг төсөл 54.7 сая төгрөг,
- Хан Хэнтий чуулгын барилгын шаардлагатай зураг төсөл 30.0 сая төгрөг,
- Цагдаагийн газрын эрүүлжүүлэх, баривчлах байрны зураг төсөл 9.9 сая төгрөг,

- Аялал жуулчлалын маршрутын дагуу түр буудаллах цэгийн зураг төсөл 13.1 сая төгрөг

Улсын төсвийн хөрөнгө оруулалт:

- "Шихихутаг нууц товчоо" түүхэн аялал жуулчлалын цогцолборын гадна цахилгаан хангамж /Хэнтий, Норовлин сум/ 50.0 сая төгрөг
- Байгаль орчин, аялал жуулчлалын яамны харьяа байгууллагуудын нэгдсэн конторын барилга /Хэнтий, Хэрлэн сум/ 1,495.5 сая төгрөг
- Аварга нуурын зүүн бүрдийг сэргээх /Хэнтий, Дэлгэрхаан сум/ 50.0 сая төгрөг
- Сургуулийн барилга, 640 суудал /Хэнтий, Өмнөдэлгэр сум/ 499.9 сая төгрөг
- Сургуулийн дотуур байрын барилга, 100 ор /Хэнтий, Батширээт сум/ 100.0 сая төгрөг
- Ерөнхий боловсролын сургуулийг олон улсын стандартад нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангах төсөл /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/ 2,000.0 сая төгрөг
- Сургуулийн барилгын их засвар /Хэнтий, Өмнөдэлгэр сум/ 198.9 сая төгрөг
- Соёлын төвийн барилгын их засвар /Хэнтий, Баян-Овоо сум/ 231.9 сая төгрөг
- Соёлын төвийн барилгын их засвар /Хэнтий, Дэлгэрхаан сум/ 147.5 сая төгрөг
- Спорт заалны их засвар /Хэнтий, Хэрлэн баян-Улаан тосгон/ 50.0 сая төгрөг
- Эрчмийн 60 айлын орон сууцын инженерийн шугам сүлжээний үргэлжлэл /Хэнтий, Хэрлэн сум, 4 дүгээр баг/ 300.0 сая төгрөг
- Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө /Хэнтий, Батноров сум, Бэрх тосгон/ 50.0 сая төгрөг
- Нийтийн орон сууцын гадна фасад /Хэнтий, Бор-Өндөр сум/ 189.8 сая төгрөг
- Эрүүл мэндийн төвийн барилгын их засвар /Хэнтий, Дэлгэрхаан сум/ 195.1 сая төгрөг

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт:

- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх төсөл арга хэмжээний зураг төсвийн үнийг бүртгэл тайланд тусгаагүй- 17.6 сая төгрөг

Аудитын илрүүлэлт:

Бараа материалын данстай холбоотой нийт 4,535.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, бараа материалын бүртгэл, тайлагналтай холбоотой 194.5 сая төгрөгийн алдаа, зөрчлийг санхүүгийн тайланд залруулсан. Залруулаагүй зөрчлийг дурдвал:

Бараа материалын нярвын тайланг гаргаагүй, бараа материалын тайланг нэр төрлөөр гаргаагүй. Үүнд:

- Бор-Өндөр сумын Цэгцүүлэн дом Өрхийн эмнэлэг – 23.1 сая төгрөг

Бараа материалын үлдэгдлийг тоолж, тооцоо бодсон акт үйлдээгүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй 4,152.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Биндэр сумын ЗДТГ – 4,119.0 сая төгрөг
- Өлзийт тосгоны Соёлын төв -12.4 сая төгрөг
- Өмнөдэлгэр сумын ЕБС -7.6 сая төгрөг
- Биндэр сумын ЕБС – 5.4 сая төгрөг
- Биндэр сумын ЗДТГ - 3.7 сая төгрөг
- Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар -1.6 сая төгрөг

Бараа материалыг дутагдуулсан 8.7 сая төгрөгийн зөрчлийг шийдвэрлэж, тооцоо хийгээгүй тул төлбөрийн акт тогтоосон. Үүнд:

- Биндэр сумын ЕБС /палк / - 3.7 сая төгрөг
- Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар /шатахуун / -0.5 сая төгрөг

Санхүүгийн тайлан дахь бараа материалын үлдэгдэл дэлгэрэнгүй болон тооллогын бүртгэлээс 64.6 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн. Үүнд:

- Баян-Овоо сумын ЭМТ -20.7 сая төгрөг
- Норовлин сумын ЭМТ -15.6 сая төгрөг
- Биндэр сумын ИТХ -5.7 сая төгрөг
- Баянмөнх сумын ЭМТ -2.2 сая төгрөг
- Дэлгэрхаан сумын ЭМТ -1.2 сая төгрөг
- Хэрлэн баян-Улаан тосгоны Соёлын төв -1.8 сая төгрөг

- Дархан сумын Цэцэрлэг - 0.7 сая төгрөг

Шатахууны норм хэтрүүлж зарцуулсан 4.8 сая төгрөгийн зөрчил илэрсэн. Үүнд:

- Биеийн тамир спортын газар - 0.3 сая төгрөг
- Жаргалтхаан сумын ЗДТГ - 0.4 сая төгрөг
- Галшар сумын ЗДТГ – 1.2 сая төгрөг
- Орон нутгийн судлах музей – 0.5 сая төгрөг
- Баян-Адарга сумын ЭМТ - 0.5 сая төгрөг
- Баянхутаг ЗДТГ - 0.5 сая төгрөг
- Оюуны шим өрхийн эмнэлэг - 0.4 сая төгрөг
- Ач манал өрхийн эмнэлэг – 1.0 сая төгрөг

Бараа материалыг арвиан хэмнэлтгүй, үр ашиггүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар зарлагдсан болон шууд зарлагдсан 86.1 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна.

- Баян-Адарга сумын ЭМТ /эм/ - 56.8 сая төгрөг
- Хэрлэн сумын ЗДТГ /нөөц өвс / -2.3 сая төгрөг
- Биндэр сумын ИТХ -2.5 сая төгрөг
- Өмнөдэлгэр сумын ИТХ -5.8 сая төгрөг
- Норовлин сумын ЭМТ -1.5 сая төгрөг
- Норовлин сумын ЗДТГ -0.9 сая төгрөг
- Биндэр сумын ЗДТГ – 4.3 сая төгрөг
- Биндэр сумын ЕБС -4.3 сая төгрөг
- Хэрлэн баян-Улаан тосгоны ЭМТ – 1.8 сая төгрөг
- Хан Хэнтий чуулга -1.1 сая төгрөгийн зөрчлүүд илэрсэн.

2.8.6 Нөөцийн бараа

Нөөцийн бараа материалын дансны эхний үлдэгдэл 80.1 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 82.8 сая төгрөг болж, 2.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7 Нөөцийн барааны үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Нөөцийн бараа	-	-	
Тэжээлийн нөөц	13.5	41.2	27.7
Бусад нөөц	66.6	41.6	(25.0)
Дүн	80.1	82.8	2.7
<i>Үүнээс, байгууллагын төрлөөр</i>	-	-	-
Төсөвт байгууллага	50.7	53.4	2.7
Төсөл/ сан	29.4	29.4	-
Төрийн сан	-	-	-
ТӨҮГ болон ОНӨҮГ	-	-	-
Дүн	80.1	82.8	2.7

Тайлант оны эцсийн нөөцийн барааны 82.8 сая төгрөг нь Газар тариаланг дэмжих сан үр тарианы нөөцөд 29.4 сая төгрөг, өвөлжилтийн бэлтгэл хангах зорилгоор малын өвс тэжээл нөөцөлж Батширээт сум 13.5 сая төгрөг, Баян-Овоо сум 0.1 сая төгрөг, Баян-Адарга сум 14.6 сая төгрөг, Бэрх тосгон 5.0 сая төгрөг, Галшар сум 9.0 сая төгрөг, Норовлин сум 5.6 сая төгрөг, Өмнөдэлгэр сум 5.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

Аймгийн Тариалан эрхлэлтийн дэмжих сан дахь нөөцийн барааны 29.4 сая төгрөгийн үлдэгдлийг тоолж баримтжуулаагүй, олон жилийн турш өөрчлөлт ороогүй, биетээр байгаа эсэх нь тодорхойгүй байна.

2.8.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 174,182.9 сая төгрөг, эцсийн үлдэгдэл 218,808.7 сая

төгрөг болж, 44,625.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №8 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	155,363.7	199,939.9	44,576.2
Барилга, байгууламж, орон сууц	118,622.6	155,565.8	36,943.2
Авто тээврийн хэрэгсэл	7,117.6	8,820.2	1,702.6
Машин тоног төхөөрөмж	13,449.1	17,304.5	3,855.4
Тавилга, аж ахуйн эд хогшил	6,586.7	7,594.4	1,007.7
Зам, гүүрний байгууламж	1,566.1	3,902.6	2,336.5
Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	6.3	6.3	-
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,748.1	1,748.1	(0.0)
Бусад үндсэн хөрөнгө	3,832.1	4,186.8	354.7
Дуусаагүй барилга, байгууламж	1,652.1	-	(1,652.1)
Ном	783.0	811.2	28.2
Биет бус хөрөнгө	18,819.1	18,868.8	49.7
Программ хангамж	206.4	199.9	(6.5)
